

МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ҮГИЙГ МЭДЭГДЭХҮҮН МЭДЭХҮҮН БА
ХЭЛЭГДЭХҮҮН ХЭЛЭХҮҮНИЙ ТАЛААС ҮЗЭХ НЬ

М. Базаррагчаа*
Б. Мөнгөнцэцэг*

Тогоо “наймаа–худалдаа; гийчин–зочин; хөх цай–хэвийн цай; ноён шиш–эрдэнэ шиш; төхөөрөх–ойлгох–гүүрэх; бадир шувуу–тонишуул; билет–пиу; хаяг–адрес; ган–болд; зөн–тоосго; жүнз–хундага; улс–гүрэн; гяндан–шорон” зэрэг үгс хос хосоороо бүрэн адил утгатайгаар тохиролцож, заан нэрлэсэн зүйл нь адил мөртөө найруулгын өнгө нь ч адил тул хэлний орчинд харилцан орлож болох онцлогтой”¹ гэж тодорхойлоод, адил утгат үгийг адил бус үгээр илтгэх, үндсэн утга нь адил боловч нэмэлт утга нь ялгамжтай, хэрэг үзэгдлийг тусгалын ухагдахууны хэмжээ, найруулгын өнгө ба үг холболтын байдал зэргээр утгын ялгамжтай (гоё-ганган=сайхан) гэх мэтээр ойролцоо үгийн гол гол шинж буюу хэлэгдэхүүн ба хэлэхүүн, мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүний шинжийг тодорхойлсон байна. Тэрээр, “ногоо:лууван” ба (өвчин) ороох : (өвчин) тусах” зэргийг ойролцоо үг болохгүй гэжээ. Мөн Тогоо “аюул-түгшүүр; уур-хилэн; хорсол-занал; хүсэл-эрмэлзэл; зуршил-занил; хэрэг-явдал; гэрч-баримт; эрүүл-чаараг; алс-хол; ядуу-зүдүү; өнөд-мөнх; алгуур-аажим; бодох-санах; арвилах-гамнах; эрхлэх-эзэгнэх; мөхөх-сөнөх; балай-мунхаг; шатаах-түлэх; авир-овор; сэцэн-сэргэлэн” гэх мэт ойролцоо үгийг иш татсан нь хоршоо үг болох ба Ю.Д.Апресяны хэлснээр эдгээрийн нэг нь нөгөөгөө тайлбарласан үг болох ажээ. Ю.Д.Апресян энэ тайлбарын тухай хэлэхдээ: “Тайлбар (толкование) нь тухайн хэлний нэгжийн үгийн сан ба хэл зүйн утгыг тайлах ба энэ нь ерөнхийдөө, таамаг санаа, баймжит утга, бараглах санаа (ассерция), ажигласан дотоод ба гадаад санаа, сонгосон сэдэл санаа гэсэн таван зүйлээс бүтэх ажээ”² Жишээлбэл,

Хүч тамир минь саяхан бялхаж
Хөвч дэлхийг хурааж захирч явсан сан
Хувь тавилан минь одоо буруулж
Хурдан хүлэг минь гэнэт зогслоо
Амьдрал үхэл хоёрын алиныг сонгохыг

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

* “Гурван Эрдэнэ” БДСургууль

¹ Тогоо (1993) *Үгийн сангийн зүйл // Орчин үеийн монгол хэл. 720 х., Хөх.*

² Ю.Д.Апресян (1999) *Новый объяснительный словарь синонимов русского языка. Первый выпуск, стр. XXXII, Москва.*

Амраг Юй минь хэлж өгөөч, надад гэжээ.³ гэхэд “хүч тамир, хувь тавилан” гэсэн хоршсон ойролцоо үгийг “бяр-бяд-хүчин-чадал-дарман⁴ –тэнхээ-тамир-ааг-чинээ-тэнхэл-тар-буль (бул)-сунчин-ид-эрч-эр бяр-ир чадал, хав” гэх мэт үгсээс, “хувь-тавилан-заяа-аз-ерөөл-буян-хишиг-төөрөг-бэлгэ-дэмбэрэл-завилаан зохиол-хутаг-оноо-барилдлага-ивээл” гэх мэт үгсээс шилэн сонгожээ. Учир нь, 1-рт, толгой холбох, 2-рт, залуу хүний тухай өгүүлж буй тул “эрч хүч, ид хав, эр чадал” гэсэн үгс ба “хувь заяа, хувь ерөөл, хувь зохиол, хувь төөрөг” гэсэн үгсийг зэрэгцүүлж байж авсан болов уу. Энэ нь Ю.Д.Апресьянаас ойролцоо үгсийг тайлбарлах дээрх таван зүйлийн сүүлийн хоёр зүйлд хамаарна. Хэрэв “хөвч” гэхийг “өвч” гэж сонгосон бол “өлзий учрал, эрч хүч, өр зүрх” гэх мэтээр солих байсан ч байж мэднэ. Иймд

Эрч хүч минь саяхан бялхаж

Өвч дэлхийг хувааж захирч явсан сан.

Өлзий учрал минь одоо буруулж

Өмөг хүлэг минь гэнэт зогслоо гэх мэтээр найруулж болно. Б.Ринчен утга ойролцоо хоршоо үгнээ “хэл ам, хэрүүл цугаан, яр шарх, хөл үймээн, сүх мадга, өвс ногоо, нутаг нуга, ухаан санаа, арга бааш, энх мэнд, өлзий хутаг, сургууль соёл, нам засаг, мөхөх сөнөх, мандах бадрах, захирах тушаах, ядах цөхөх, тэтгэх туслах, сурах судлах, өршөөх энэрэх, халуурах бүлээрэх, тас зад, үлт ялз, зулга тас⁵ зэрэг үгсээс гадна, төсөөт ба төсөөрхүү үгс болох “яр-бэр, гань-галзуу, хэл-ам, энх-тунх, арай-чарай, алах-талах, хахах-цацах, талт-мөлт, тас-няс, түг-таг, сүр-сар, шаг-шуг, хангир-чингэр, чүү-чаа, нэй-най, жиг-жуг, өм-цөм, аахь-уухь, ундуй-сундуй, нугар-бяцар, өм-ём, шалз-ялз, лад-ландгар, яр-ярсгар, ёр-ёхир, сав сая, дөв-дөрвөлжин, тув туранхай”⁶ зэрэг үгсийг багтаажээ. Б.Ринчен гуай ойролцоо үгсийг хоршин хэрэглэхээс гадна, хос мөр бүтээдэг учрыг аман ба бичгийн хэлний жишээгээр харуулснаас ганц хоёрыг дурдвал,

Анчин гөрөөчин, авчин шувуучин

Шагайчин харвуулчин нийгэм бүхийгээр

Найр их цэнгэлд авцарья гэж хэлжээ.

Үхсэнийг мөрөөр үлдэж явсан

Хатсаныг мөрөөр хайж явсан

Зан муутын үр

Заяа муутын үхин гээшиб.

Санасан юмыг нь бүтээж хайрлагтуй

Сарвайсан юмыг нь тусалж хайрлагтуй⁷ гэхэд “анчин гөрөөчин (авчин шувуучин), шагайчин харвуулчин, найр цэнгэл” (завсар нь “их” хэмээх тэмдэг нэрийг шургуулсан нь “ув улаан” мэтэд шургасан “в” оруулбар бүтээврийн адил “их” хэмээх үгийг оруулбар болгожээ) гэсэн ойролцоо үгийг хоршсон бол “зан, санасан” хэмээх үгнээ дүрслэг утга бүхий “заяа, сарвайсан” хэмээх үгийг хоршсоныг хоёр мөр өгүүлбэр

³ Алтан бумбан дахь лишийн цэцэг (2009) 30-31 х., Улаанбаатар.

⁴ G.J.Ramstedt (1935) *Kalmückisches wörterbuch*, p. 387, Helsinki.

⁵ Б.Ринчен (1967) *Монгол бичгийн хэлний зүй, Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр*, 26-33 х., Улаанбаатар.

⁶ Б.Ринчен (1967) *Монгол бичгийн хэлний зүй, Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр*, 11 х., Улаанбаатар.

⁷ Б.Ринчен (1967) *Монгол бичгийн хэлний зүй, Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр*, 66-77 х., Улаанбаатар.

болгон толгой холбосон нь найруулгын нэг ур маяг болжээ. Энэ тухай миний бие тодорхой өгүүлсэн билээ⁸ Харин

-Ар газрыг айраг дайраг хийгээд

Өвөр газрыг өгрөг дайраг хийгээд зугтаагаад явжээ.

-Нарийн өвсийг нахийлгалгүй гэтэж

Бүдүүн өвсийг бөхийлгөлгүй цөмцөж

Гэрийн цоорхойгоор гэтэж харав гэнэ.

-Буулгах охины эрэн мярааныг чи ав!

-Мангасын хувилгаан, нэгэн эрвэн сэрвэн мод буюу зэрэгт орсон (тодлон ялгасан) үгс нь төсөөт үг, “Бид Дэгү Юнхэний айл аймаг, нөхөр хань билээ. Энэ хуушаан хэдий согтуу галзуу боловч чадал эрдэм гүн (Шэн чен хуй хэмээх түүх). Шинэ бэрийг үзвээс, зүс өнгө ану зүйтэй бөгөөд бичхэн эр эм хоёул маш эвтэй найртай”⁹ гэвэл “айл аймаг, согтуу галзуу, эвтэй найртай (эв найртай) гэвэл төсөөрхүү үг болно.

Ю.Д.Апресян нэг язгуурт ойролцоо үг (заснуть-уснуть, заточить-наточить-отточить; варить-отваривать, мести-подметать, подбить-подшибить, сопровождать-сопутствовать, чернеть-чернеться, кусать-кусаться, болезнь-заболевание, наследие-наследство) нь ойролцоо утга бүтээх эх үндэс болно.¹⁰ гэж үзэж байна. Мөн Л.А.Новиков (выругать-отругать, заглавие-заголовок, качать-раскачивать, дымить-дымиться)¹¹ А.В.Лагутина (мандариновый-мандаринный)¹² А.П.Евгеньева нар ч тэгж үзжээ. А.П.Евгеньева “Нэг язгуурт ойролцоо үгс нь тэдгээрийн харьцаанаас шалтгаалж шаталсан олон холбоог бий болгож, янз бүрийн хэрэглүүрээр хүрээгээ тэлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг”¹³ (Өгүүлбэр “струсил...страх”, “боязнь...пугало” гэж орсон жишээ татсан ба

1. Мы с Иваном друзья со школьных лет.

2. Мы с Иваном дружны со школьных лет.

3. Мы с Иваном дружим со школьных лет.

4. Мы с Иваном в дружбе со школьных лет.

5. У нас с Иваном дружба со школьных лет. гэж нэг язгуурт ойролцоо үг бүтэх хувилах ёсыг өгүүлбэр, эхийн дотор харьцуулжээ. И.А.Мельчук, ойролцоо үгийн тухай “Өгүүлбэрийн дотор гол буюу түлхүүр үг (C_o) нь идэвхтэй тохицож чаддаг ба утгаараа түлхүүр буюу гол үгтэй (C_o) тохирох үгсийг ойролцоо үг (Syn) гэнэ”¹⁴ гэж тодорхойлоод, орос хэлний “желание (хүсэл, хүслэн) =желать (хүсэх) гэхэд утгаараа

⁸ М.Базаррагчаа (1993) Монгол хэлний хоршоо үгийг ангилах нь. Монгол хэлний хоршоо үг, 7 х., Улаанбаатар.

⁹ Б.Ринчен (1967) Монгол бичгийн хэлний зүй, Өгүүлбэр зүй, дөтгөөр дэвтэр, 75 х., Улаанбаатар.

¹⁰ Ю.Д.Апресян (1974) Лексическая семантика. Синонимические средства языка, стр. 228-229, Москва.

¹¹ Л.А.Новиков (1990) Синонимия. Лингвистический энциклопедический словарь. стр. 229, Москва.

¹² А.П.Евгеньева (1966) Основные вопросы лексической синонимии. Очерки по синонимике современного русского литературного языка, стр. 124, Москва.

¹³ А.П.Евгеньева (1966) Основные вопросы лексической синонимии. Очерки по синонимике современного русского литературного языка, стр. 28, Москва.

¹⁴ И.А.Мельчук (1974) Опыт теории лингвистических моделей “Смысл ↔ Текст” (Семантика, синтаксис), стр. 82, Москва.

тохирох боловч өөр үгсийн аймагт хамаарах тул ойролцоо үг биш, өгүүлбэрийн салаалбар (Der.) болно” гэжээ. Цаашилбал, тэрээр, толины үгийн товч тайлбар болон туйлын ойролцоо үгээс гадна, тухайн эхийн дотор хуурмаг ойролцоо үгс нь бүрэн атлаа байнга саармагшиж байдаг. Жишээ нь: “Ширчин эхнэрийнхээ өөдөөс гайхасхийн хараад, үгийн уургаар санааны морийг барих гэж нүдээ аньсхийн, бодлого болсон царайгий нь ажиглан мишээвээс...” (Б.Ринчен.) гэхэд

“царай-хүний нүүрийн өнгө зүс, дүр төрх”

”зүс- 1. хүний нүүрийн дүр төрх, 2. мал амьтны зүс”

“нүүр-хүн амьтны толгойн өмнө тал, магнайгаас доод эрүүний зах хүртэлх хэсэг” хэмээх ойролцоо үгсээс “царай” гэдгийг “нүүр” гэж болно. Энэ нь “нүүр” нь бүхэл “царай” нь хэсэг буюу нүүрийн шинж тул нэгий нь нөгөөгөөр сольж болдог нь уул өгүүлбэрт орохдоо энэ хоёр үгийн ялгараа нь арилж саармагшина. Тиймээс “нүүр царай, царай зүс (зүс царай), зүс өнгө (өнгө зүс), царай төрх” гэх мэтээр хоршин хэлэхэд ойролцоо үгсийн утгын ялгаа бүдгэрч, нэгэн утга болдог. Ийнхүү ойролцоо үг саармагших талаар М.А.Кронгауз өгүүлэхдээ орос хэлний копать (малтах)-рыть (ухах), төнхөх, өрөх (erükü) хэмээх хоёр үгийн “рыть” гэдэг багаж зэвсэг төдийгүй, “гараар ухах” гэснээрээ ялгаатай боловч “копать/рыть ему лопаткой” гэхэд дээрх үгийн ялгаа арилан саармагшина.¹⁵ гэжээ. И.А.Мельчук “Тэр хувцсаа угаалаа” гэхийг “хиргүй болгох” (цэвэрлэх) гэгчээр сольж болох тул ойролцоо үг байж болно.¹⁶ гэж үзэж болно. Энэ нь “хувцасны хирийг угаалаа/арилгалаа/цэвэрлэлээ” гэхэд сүүлчийн хоёр үг нь ойр утгатай боловч “угаах” гэдэг нь заавал “ус” хэрэглэх болно. И.А.Мельчук ойролцоо үгийн утга нь хол ойр гэж байхаас гадна, бие биеэ нөхсөн (“агрессия=нападение” гэхэд эхнийх нь сүүлчийнхээ нэг хэсэг нь байх жишээтэй.)¹⁷ гэж ангилаад, язгуур нэг ойролцоо үгийг

1. $V \rightarrow N_{sub}$. (хавд-р, ай-дас, сийл-бэр, жарга-л, тох-м, сур-лага, буу-дал)

2. $V \rightarrow N_{adj}$. (хат-уу, ай-мтгай(хай), шуугь-уур, горзго-р, сийр-г, хөш-үүн)

3. $N_{sub} \rightarrow V$ (мал-ла-, бах-рх-, байр-ш-, гал-ла-, ой-шоо-, санаа-шир-, мөс-т-)

4. $N_{adj} \rightarrow N_{sub}$. (малч-н, бүрээч-н, бор-лдой, цагаа(н)-дай, дүү-мэд, урт-раг, хээр-гч(хээгч))

5. $N \rightarrow N_{adv}$. (хай-вга, тат-га, хаз-га, ух-с, яр-с, булт-с, арви-га, арвис) гэх мэт үүсгэвэр үүсвэр хоёрыг утга тохировч, өөр өөр үгсийн айд багтах тул өгүүлбэрийн салаалбар (дериватема) болно¹⁸ гэжээ.

Ю.Д.Апресян хуурмаг ойролцоо үгс (квазисинонимы) нь төрөл-зүйл (багтсан утгат “болеть-саднить” cf. явах, хөдлөх, давхих, таврах, хатирах-хурдлах), зүйл-зүйл (нөхсөн утгат “жечь” (галдах, түймэрдэх, шатаах, түлэх)

- ломить (нахийлгах, хотойлгох, нугалах)

- нить (янгинах, шархирах, чимчигнэх)

- саднить (загатнах, хорсох, сэргэвчлэх)

- сверлить (өрөмдөх, нүхлэх, цоолох)

¹⁵ М.А.Кронгауз (2005) Семантика. стр. 145, Москва.

¹⁶ И.А.Мельчук (1974) Опыт теории лингвистических моделей “Смысл ↔ Текст” (Семантика, синтаксис), стр. 46, Москва.

¹⁷ И.А.Мельчук (1974) Опыт теории лингвистических моделей “Смысл ↔ Текст” (Семантика, синтаксис), стр. 82, Москва.

¹⁸ И.А.Мельчук (1974) Опыт теории лингвистических моделей “Смысл ↔ Текст” (Семантика, синтаксис), стр. 84, Москва.

- *стрелять* (буудах, буу тавих, харвах)

- *свербеть* (загатнах)¹⁹ зэрэг жишээ татаж, “Иймэрхүү задгай үүр эгнээг батлах гэдэг нь илүүц биш юм. Тиймээс хуурмаг ойролцоо үгсийн утгын янз бүрийн байдал нь элдэв төрлийн дотоод бүтцийг үүсгэж, мөн янз бүрээр саармагшина. Энэ нь ихэвчлэн төрөл зүйлийн утгатай ойролцоо үгсийн хооронд бий болох ба “зүйл-зүйл”-ийн хоорондох ялгаа саармагших нь онолын хувьд бүрэн боломжтой ч тодорхой жишээний хувьд эрс ховор байдаг”²⁰ гэжээ. Энэхүү хуурмаг ойролцоо үгсийг “эх сэдвийн ойролцоо үг” гэх ба монгол хэлний “бүдүүлэг” гэснийг “бүдүүн хадуун, бүдүүн бааз, болхи толхи, бүдүүн бараг, зэрлэг, мөхөс дорой, буурай бүдүүлэг, болхи заваан, эв хавгүй, ур дүйгүй, болхи бохир, бохир балиар, бохир тахир, хөшүүн хашин, бааруу, хойрго удаан, алхаг залхуу, хойрго цаарга, хашин хойрго, хойрго залхуу, цалгар хойрго, цалгар назгай, наазгай, алжуу залхаг, мохдог хашин, алмай назгай, нойрмог назгай, удаан назгай, мангар бүдүүлэг, алан салан, салан задгай, алмагай назгай, алмагай хайнга, алжуу залхуу, налгар назгай, цалгай осол, цалгар задгай, бохир бохио” гэх ойролцоо утга бүхий хоршоо үг бүтээжээ. Хэдийгээр нэг язгуурт хоршоо үг байвч тухай тухайн эхэд бие биеэ орлох ба Ю.Д.Апресяны үзсэн шиг “болхи толхи” гэсэн төсөөт хоршоо үгийн нэг нь нөгөөгийнхөө тайлбар болж чадна.

“Зан төрхийн назгай байдалтай нягт холбоотой байдаг монгол хүний өөр бас нэг шинж байдал бол түүний ямар нэг тийм зарчимлаг залхуурал юм” (Н.М.Майский) гэхэд “назгай, залхуу” гэсэнтэй дүйх ойролцоо утгыг дээрх ойролцоо хоршоо үгээс хямдхан олж болно. Жишээ нь: “хойрго хөшүүн, хөшин алхаг, алжуу, залхаг, налгар, цалгар, хайнга, удаан” гэх зэрэг үгсээр сольж болно. Ингэж ойролцоо үгсийн үүрт буй үг нь хэлэхүүний талаас утгыг тодруулахын тул ижилсэх буюу саармагших, ондооших буюу ялгарах, мэдэхүүний талаас, тухайн ойролцоо үгсийн эгнээний аль нэгэнд баймж ба үнэлэмжийн “үнэр танар” оруулбал найруулбарын зэрэглэл (дээд ба дунд, доод ба хар яриа) бий болно.²¹ Жишээ нь: 1. манд-, урга-, гий-, гар-; 2. бадар-, хөгж-, манд-, цэцэглэ-, дэгж-, дэлгэр-, төлж

А. 1. Дээд найруулбар: нар манд-, нар урга- (Саруул сайхан сар аа! Сав ертөнцийг нар гийгүүлж, чөлөөлмөгц оронд нь чи мандана. Сүрхий хүчтэй гэрэлд чинь шөнө харанхуй дийлэгдэнэ. (Д.Нацагдорж) Тэр мэт тийм ийм үг хэлэлцэн суутал удалгүй өглөө болж, нар ургав. (Ц.Дамдинсүрэн)

2. Дунд найруулбар: нар гий- (Ариун урсгал дор нь мяралзаж, алтан нар дээр нь гийхэд догийн салхинаас амраг олох мэт довтлох далбаа шуургыг хүснэ.) (М.Ю.Лермонтов)

Б. 3. Доод найруулбар: нар гар- (...нэгэн үе сууж, заримдаа хэвтэж, үүр гэгээрч, нар гарахыг хүсэж байлаа.) (Ц.Дамдинсүрэн)

4. Хар ярианы найруулбар: нар сар гэрэлт- (Гэтэл манайх гэдэг нар сар гэрэлтсэн айл байдаг.) (С.Дашдооров)

¹⁹ Ю.Д.Апресян (1974) *Лексическая семантика. Синонимические средства языка*, стр. 225, Москва.

²⁰ Ю.Д.Апресян (1974) *Лексическая семантика. Синонимические средства языка*, стр. 235, Москва.

²¹ М.Базаррагчаа (2005) *Монгол хэлний өгүүлбэр судлал*, 153-156 х., Улаанбаатар.

Жич, “Асар удалгүй тэнгэр гэгээрч, цэлмэг огторгуйд алтан наран тодроход... (Ц.Дамдинсүрэн) гэхэд “нар гийх”-тэй адил юм.

А.1. Дээд найруулбар: бадар- Бидний гурван залуус

Боловсон хүчний тэргүүс.

Буурай бүдүүлгийг халж

Баатар хувьсгалыг бадруулна. (Д.Нацагдорж), цэцэглэ-, өөдөл-, өгс-, дээшил-, дэвш-(Ганцхан Улаанбаатар хотноо бүсгүйчүүдийн байдал урагш давшиж хөдөөнөөс ирсэн бүсгүйчүүдийг дэвшүүлэн хөгжүүлж байсан учир...)(Ц.Дамдинсүрэн), урга-, боловсор- (...зуун цэргийн хамт бусад зуутан мянгатаанаа дагуулан харвал намнал хийж, цэрэг боловсруулж явтал...))(Б.Ринчен), ахь-, дөх-, урагшил-

2. Дунд найруулбар: хөгж- (Энэ бол улс орон маань түргэн хөгжиж, хүн ард маань түргэн соёлжиж байгаагийн нэг гэрч мөн)(Ц.Дамдинсүрэн), дэлгэр-(Цагийн улирал зуны дундад хүрч, тунгалаг наран өндөр мандаад түмэн бодисын хөгжин дэлгэрэхийг баясан толилуулахуйяа...) (М.Ядамсүрэн), өрнө-(Цээмаагийн энэ мэтийн атаархах сэтгэл улам өрнөсөөр одоо мэх заль хэрэглэхэд хүргэв)(Ц.Дамдинсүрэн), өргөж-, (төлж-(tölji-), өс-, бойж-, сайжир-, олиир- (Орон сууцны газар хэрээ олиирсонд сэтгэл түгшинэ.) (Д.Батбаяр), элбэгш-(Өдөх хоног өнгөрөх бүр хоол хүнс, бараа туруу аажим аажмаар элбэгшиж эхэллээ.) (Д.Мягмар), үрж-, торни-(Харин охин минь өдөр хоног өнгөрөх бүр мэдэгдэхүйц өсөж торнисоор байлаа)(Д.Мягмар), өнөрж-, элбэгж-, тэл-(Баг сум дансанд хүртэл тэгж бичигдэнэ шүү дээ гэж санахаас сэтгэл тэлээд явчих шиг,...)(Д.Мягмар)

Б.3. Доод найруулбар: дэвж- (Унд хоолын хүчээр ухаан чадал сэргэнэ. Эд агуурсын дэмээр хорвоо ертөнц дэвжинэ.) (Винү Шармаа), дэгж-

4. Хар ярианы найруулбар: манд- (Урьд, Цэ гүн, хутагтад Туул голд давхарлаг модон тагт байшин босгож өгөөд, хутагтын шадар хүн болж мандтал, Цэ гүнгийн бага хатан Норов гэгчийн гялалзсан хар нүд нь дээрхийн таалалд нийлээд ...) (Б.Ринчен), амьдрал цэцэглэ- (цалин мөнгө бууж, амьдрал цэцэглэнэ.) (О.Самдан) нар сар гэрэлт- (Гэтэл манайх гэдэг нар сар гэрэлтсэн айл байдаг.) (С.Дансдоргов)

Ю.Д.Апресян ойролцоо үгс нь нэг үгсийн аймагт багтана гэсэн бол О.Д.Прокопчик төсөөт үгс нь өөр өөр үгсийн аймагт хамаарч болох ажээ²² Ойролцоо үгс нь өгүүлбэрт нэг үгнээ захирагдан, утгын нарийн ялгаа гаргаж, мэдрэмжийн хир хэмжээг заадаг бол төсөөт үгсийн нэг нь нөгөөгийнхөө утгыг нарийвчилж чаддаггүй, харин андуурах ташаарах, алдаа гаргахад хүргэдэг ажээ. Нэг язгуурт “*economic:economical, classic:classical, politics:policy*” зэрэг үгсийг зарим нь ойролцоо үг гэдэг ч зарим түүнийг зөвшөөрдөггүй байна.

Л.Н.Федотовагийн үзэж байгаагаар ойролцоо үгс нь нөгөө үгийнхээ утгаар орсоор ойролцоо утгаа гээвэл төсөөт үг болдог²³ Жишээлбэл, *masterful* (чадварлаг): *masterly* (захирангуй); *appetitive* (дуриил): *appetizing* (дуртай).

О.Д.Прокопчик төсөөт үг нь хэлэнд байдаггүй, харин ярианы хэлнээс тольд оруулдаг ба ижил үг, салаа ба ойролцоо утгатай мөргөлдөн байж үүснэ²⁴ гэжээ. Төсөөт

²² О.Д.Прокопчик (2005) *Семантические механизмы и прагматические функции паронимии. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук.* стр. 48, Санкт Петербург.

²³ Л.Н.Федотова (1989) *Паронимия в современном английском языке: структура и функции.* Автореф. дис. канд. фил. наук, стр. 17, Минск.

- 1) ойролцоо утгатай төсөөт үг (*итгэх-итгэмжлэх*)
- 2) эсрэг утгатай төсөөт үг (*энд-тэнд, ийм-тийм*)
- 3) салаа утгатай төсөөт үг (*шавайх-шовойх-шөвийх*)
- 4) зүйлийн буюу гарлын утгатай төсөөт үг (*балаг-булаг-бэлэг-бүлэг-(полог)*²⁵ гэж ангилсан билээ. Энэ санаанд тулгуурлан, “Хоёроос дээш зэргэд ба зэргэд бус, энгийн ба нийлмэл өгүүлбэрт цөм өгүүлбэр давтан орвол түүнийг төсөөт өгүүлбэр гэнэ”²⁶ гээд, эсрэг ба ойролцоо, зүйлчилсэн ба солбицсон өгүүлбэр гэж ялгасан билээ. Төсөөт ба ойролцоо үгс нь тэмдэглэхүүн тэмдэглэгдэхүүний хувьд эсрэг шинжтэй ба дараах харьцууллыг үзнэ үү. Үүнд:

Ойролцоо үгс

ондооших тал нь

Төсөөт үгс

1. Тэмдэглэхүүн нь өөр,
тэмдэглэгдэхүүн нь ойр
a) *инээх-мишээх-хөхрөх*
b) *тэргүүн-толгой-тархи*
c) *хачин-сонин-жигтэй*
d) *өрнө-баруун, умард-хойд,*
эрт-урьд
2. Өөр өөр гаралтай үгс байдаг.
a) *бүгд-булт-нийт-цөм-цуг-хотол*
b) *нийт-нийгэм, бүх-бүгд*
3. Туйлын ойролцоо үг утгаараа
бүрэн тохирно. *мөнгө-зоос, муур-*
мий, нүд-мэлмий, найз-түни, нас-
сүүдэр, намтар-наян, түгэх-
түвэх, тахиx-тайх, үйл-лай-ланчиг

1. Тэмдэглэхүүн нь ойролцоо,
тэмдэглэгдэхүүн нь ойр
a) *залга-мж-л_v-лⁿ, үйл-д-вэр-лэ^v-л_N*
(syn.)
b) *тэнд-энд, энэтээ-тэртээ,*
бүстэй-бүсгүй, ингэх-чингэх
(anti)
c) *алаг-элэг (доог), өвөр-өмнө,*
холбоо-сүлбээ (pole.)
d) *цардай-цордой-цурдай-,*
чардай-, цэрдий-, цүрдий-,
орилох-чарлах, алхаг-залхаг,
урвах-хөрвөх, яниших-шаниших,
яг-таг, яв-тав (poli.)
2. Нягталбал, нэг гаралтай үгс
байдаг.
балаг-булаг-бэлэг-бөлөг-билиг
цээр-аалз, ховдог-хомхой, хил-
хязгаар
3. Ойролцоо утга бүхий төсөөт үг
нь утгаараа бүрэн тохирдоггүй.
мурий-сарий

²⁶М.Базаррагчаа (2002) *Монгол хэл*-9. 124 х., Улаанбаатар.

4. Холын гаралтай үгс байж болно.
ноос-унгас, таарах-тохирох, тав-
тух, нялх-нярай, өгсөх-өөдлөх,
өөр-өмнөө, санах-сэдэх, тавлах-
тухлах, тахиx-тайх, тонох-
талах, таарах-тохиох, тээр-
төвөг, төлөв-төрх, утга-учир

4. Ойрын гаралтай үгс байж болно.
нийцэх-нийлэх, солих-холих-сэлэх,
сэхээрэх-ухаарах, хэлбийх-хэвийх,
яриг-яриг, уйлах-хайлах,
умбах-шумбах, босуул-босгуул

Ижилсэх тал нь

2. Хэлэхийн цуваанд солих боломжтой

алаг цоог; гай цөв; сөхөвч-хавхаг;
өргөл барьц; өргөл-даатгал; өргөл-
мөргөл; өргөл-хандив; өргөл-
хүндлэл; уранхай-ноорхой- цоорхой
-навтархай-онгорхой; ярих-дийлэх-
давах; хэрэг-явдал-ажил үйлс

бөхжилт-бэхжилт, оочин-
цоочин, хамх-хэмх, хамхрах-
хэмхрэх, өвдөл-цөвдөл, дуусах-
төгсөх, ховдог-сувдаг

3. Нэг язгуураас үүсэлтэй үг байж болно.

гарз-гарлага, биежилт-биелэлт,
тааварлах-таамаглах

өмч-рх-л_н, хэцээ-рх-л_н, сур-га-мж-л_н-л_н,
суу-р-н-ш-л, урам-д-лага, уя-(н)-р-мхай


4. Нэг үгсийн аймагт багтана.


харуул-манаа-цагдуул-сахиур
(сахиул)
мандах-ургах-гийх-гарах
ихэнх-олонх-дийлэнх
огтлол-огтлолт-огтлоос-огтлоо-
огтлоодос. балайтах-балайтах

өд сөд, өдлөх-сөдлөх, ахих-дахих,
балхайх-болхойх-булхайх-бялхайх-
бэлхийх-бөлхийх-бүлхийх, унжлага-
санжлага, унжих-санжих,
унжуурга-санжуурга, унжуу-санжуу

Төсөөт үгс нь тэмдэглэхүүний хувьд ижил үгстэй, тэмдэглэгдэхүүнийхээ хувьд ойролцоо үгстэй тус тус ойр дөт байдаг учир энэ хоёрын дундын шинжтэй юм. Иймээс нэг язгуурт үгс нь ойролцоо ба төсөөт үгийн аль алинд байх үзэгдэл болно. Гэтэл үгийн хувилбар нь тэмдэглэхүүний хувьд төсөөт үгтэй адил авч тэмдэглэгдэхүүний хувьд салаа утгатай адил юм.

Нэг язгуураас дагаврын аргаар бүтсэн үгсийн дагавар нь өөр дагавартай тэнцүү утгатай байвал ойролцоо үгс болно. Жишээ нь:





“Ойролцоо утгатай бүтээвэр нь өөр хоорондоо бүрэн тохирохын зэрэгцээ заримдаа эргэлзээтэй байдаг ч тэдгээрийн утгаараа ялгарах нь янз бүр байдаг ойролцоо утгын нэгэн хэв маяг болдог. Ойролцоо утгат дагавар нь тухайн эхийн дотор харилцан сольж болох, утгаараа адил өөр дагаврууд байдаг”²⁷ хэмээн үзэж байна.

Н.Б.Дугаров буриад хэлнээ ойролцоо утгатай дагавруудыг нэг язгуурт залгаж, ойролцоо үг бүтээх нь элбэг ба эдгээр нь утгаараа нэн ойр, ихэвчлэн найруулгын өнгө аясыг ялгадаг²⁸ гээд,

- lya-lta* (бусаалга-бусаалта, заналга-заналта, золголго-золголто, шалгалга-шалгалта)
- l-lang* (жаргал-жаргалан, хүсэл-хүслэн)
- lta-buri* (сасуулалта-сасуулбари, жэшиээлэлтэ-жэшиээлбэри)
- lya-buri* (заһалга-заһабари, түлэлгэ-түлбэри)
- liy-rqai* (уһалиг-уһархуу, гүбээлиг-гүбээрхүү, хадалиг-хадархуу)
- rqai-rqai* (хадархаг-хадархуу, заһархаг-заһархуу, чамуурхаг-чамуурхуу)
- tai-rqai* (бараатай-бараархуу, томоотой-томоорхуу, нюргатай-нюргархуу)
- tar-taqai* (эдимэр-эдимхэй, уумар-уумхай)
- na-si* (саана-сааша, наана-нааша)
- daki-durār* (нэгэдэхи-нэгэдүгээр)
- btur-siy* (хүхэбтэр-хүхэшэг, улаабтар-улаашаг, гашуубтар-гашуушаг) ойролцоо дагаврыг жагсаасны дээр ойролцоо утга бүхий төсөөт үг бүтэхийг *заһалта-заһабари-заһабарилга*²⁹, *ажсагла*²⁹-*ажсаглалга*²⁹-*ажсаглалта*²⁹ зэрэг жишээгээр тайлбарлажээ. Харин тэрээр эдгээрийг ойролцоо үг гэсэн бол бид ойролцоо утга бүхий төсөөт үг


²⁷Т.Н.Павлов (2007) *Разновременная словообразовательная синонимия в древнерусских житиях. Системное и асистемное в языке и речи.* (Материалы международной научной конференций. Иркутск, 10-13 сентября 2000 года). стр. 89, Иркутск.

²⁸Н.Б.Дугаров (1978) *Лексические синонимы в современном бурятском литературном языке.* стр. 25, Москва.

гэсэн ба “батадхалга, бэрхэмээлгэ, гайхалга” зэрэг үгийн “-га” дэд бүтээвэр (субморф)-ийн шинжтэй бололтой.

Нэр ба үйл язгуурт залгасан нэр үйл бүтээх дагавар нь урагш хойш үгсийн айгаар ижилсэж төсөөт үгс бүтээнэ. Жишээ нь:

$t\ddot{u}l\ddot{u}-g\ddot{e}s\ddot{u}-le^v$ -(төлөөсөл-), $doki-y\ddot{a}-l\ddot{a}^v$ -(дохиол-), $siba-r-da_v-l^N$ (шавардал), $jang-si-l^N$ (занишл), $jori-\gamma-si^v$ -(зоригш-), $jori-\gamma-j\ddot{i}^v$ -(зоригжс-), $jori-\gamma-l\ddot{a}^v$ -(зоригло-), $jori-\gamma-j\ddot{i}^v-l^N$ (зоригжил), $qim\ddot{i}-y\ddot{a}su-l\ddot{a}^v$ -(хуниасал-), $qori-\gamma-l\ddot{a}^v$ -(хоригло-), $ol-ja-l\ddot{a}_v$ -(олзол-), $\ddot{u}ile-d-b\ddot{u}i-j\ddot{i}^v-lte_N$ (үйлдвэржилт), $sege-mji-le_v-l^N$ (сэрэмжлэл)²⁹ Нэг язгуурт залгасан дагаврууд нь өөр хоорондоо бие даасан ойролцоо үг бүтээхийг ойролцоо ба төсөөт үгийн дундын буюу хоёрдмол шинжтэй гэж үзэж болно. Үүнийг авиалбар ба бүтээврийн түвшинд ялгавал



²⁹ Б.Идэрбаяр (2005) Ойролцоо утга бүхий төсөөт үгс. Монгол хэлний төсөөт үг, 18-26 х., Улаанбаатар.

Зарим эрдэмтэд “Нэг язгууртай, ойр дуудлагатай, харин утгаараа өөр ч хааяа утгаараа заримдаг тохирох “ароматный–ароматический, банковский–банковский, встать–стать, героический–геройский, драматический–драматичный” гэх мэт үгсийг төсөөт үг”³⁰ гэж үздэг. Орос хэлний төсөөт үгсийг хоёр дахь чиглэлээр Ю.А.Бельчиков, М.С.Панюшева (Словарь паронимов современного русского языка, М., 1994); Э.В.Кузнецов (Лексикология русского языка, М., 1989), М.И.Фомина (Современный русский язык, Лексика, М., 1977), В.И.Красных (Толковый словарь паронимов русского языка, М., 2003) нар тодорхойлж байна. Гэтэл О.С.Ахманова тухайн үгийн бүтээвэр нь авиа ба утгын хувьд заримдаг тохирох нь буруу зүйл буюу үгийн наадам болох үгсийг төсөөт үгс³¹ гэж үзсэн байдагчлан А.Н.Гвоздев (Очерки по стилистики русского языка, М., 1965), Ю.С.Степанов (Основы общего языкознания, М., 1975), Н.В.Крылова (Паронимы в современном английском языке: идиотнический и функциональный аспекты: Дис.кан.фило.наук, СПб., 1993), Н.П.Колесников (Семонимические словари. I. Словарь паронимов русского языка, Ростов-на Дону, 1995) төсөөт үгийг өөр өөр язгууртай үгс авианы бүрэлдэхүүнээрээ ойролцоо гэж үзсэн байдаг ажээ. Гэтэл О.В.Вишнякова төсөөт үгсийн хүрээг хумьж, “Янз бүрийн ухагдахууныг илтгэх тоо хүйс зэргээрээ адил, нэг үгсийн аймагт багтах ба нэг үгэндээ өргөлттэй нэг язгууртай, дуудлагаараа адилгүй ч ойролцоо үгсийг төсөөт үгс”³² хэмээн тодорхойлсон байна.

Монгол хэлний төсөөт үг нь утгаараа ойролцоо ба эсрэг, зүйлчилсэн ба салаалбарын аль алинаар байдаг онцлогтой юм.

О.А.Лазарева төсөөт үг нь ойролцоо үгстэй адилаар бүрэн ба бүрэн бус байхын зэрэгцээ хуурмаг төсөөтэй үг (*мирный–мировой–мирской; классный–классовой*) байдаг гээд, “Утга хэлбэрийн аль аль нь хутгалдсанаас яригч сонсогч андуурдаг “актер–артист, моряк–матрос, советник–советчик, терпеливый–терпимый, душевный–духовный, потомок–предок” зэрэг үгсийг холимог үгс (таронимы)³³ байдаг” гэжээ. В.В.Морковкин зэрэг эрдэмтэд ойролцоо ба төсөөт үг хоёрын завсар холимог үгс ялгарч болох ба ойролцоо үгс нь төсөөт үг болтлоо (*дипломант–дипломник*) ондоошиж, төсөөт үг нь ойролцоо үг болтлоо (*примириться–смириться*) ижилшдэг гэж хөдлөнг талыг тэмдэглэсэн байна. Монгол хэлнээ ийм холимог үгс байж болох юм шиг санагдана. Жишээ нь: *өсгийдөх* (өсгийнөөс барих, өсгийдөх мэх) –*өсгийлдөх* (өсгийг дээрээ зогсох, өсгийлдөх мэх) гэхэд “-л”-гүй нь “иууд үйлдэх”, “-л”-тэй нь “иууд бус үйлдэх” (давхар үйл гүйцэтгэх) утгатай боловч хэрэглэхдээ хольж хутгадаг байна. Харин “*өсгөлөн* (торниун бие махбодь)-*өсгөлүүн* (нялх хүн амьтны бие бялдар эрүүл чийрэг), *илбэрхүү* (таатай, зохистой)-*илбэрхий* (ялгуун эвтэй, уран зөөлөн аргатай), *инээх* (баярласан нь нүд нүүр, дуу аялгаар илрэх)-*инээмсэглэх* (баярласан нь хөнгөнөөр илрэх) гэвэл авиа болон бүтээврийн хувилбараар үүссэн үг болох биз.

³⁰ Д.Э.Розенталь, М.А.Теленкова (1985) *Словарь-справочник лингвистических терминов*. стр. 198, Москва.

³¹ О.С.Ахманова (1966) *Словарь лингвистических терминов*. стр. 313, Москва.

³² О.В.Вишнякова (1987) *Паронимия в русском языке*. стр. 24, Москва.

³³ О.А.Лазарева (2003) *Тарономы-слова, которые смешиваются в употреблении*. “Лингвистика, методика и культурология в преподавании”, стр. 78-79, Санкт-Петербург.

Ойролцоо үгийг судалсан эрдэмтэд мэдэгдэхүүний тал болох бодит утгад түшиглэн нэг юмыг олон янзаар нэрлэсэн а) *аян-жсин, зам-гал тогоо, цав манз, манз зоог*; б) *алт-маниад, загвар-моод*, в) *мангаа-мангас, андар-дэлгэц* эсвэл хэлэгдэхүүний тал болох хийсвэр утгад тулгуурлан нэг ухагдахууныг олон янзаар нэрлэсэн (*дайн-байлдаан-тулалдаан, гандах-онгох, бэлдэх-зэхэх-базаах-төхөөрөх, бүү-битгий*) гэж хоёр ангиларын зэрэгцээ 1) туйлын, 2) утгын, 3) найруулгын, 4) эхийн ойролцоо үг гэж ангилсаар иржээ. Үүнийг агуулга ба хэлбэр, зогсонги ба хөдлөнг талаас барагцаалбал, туйлын ойролцоо үг нь мэдэгдэхүүний талд, утгын ойролцоо үг нь хэлэгдэхүүний талд, найруулгын ойролцоо үг нь хэлэхүүний талд, эхийн ойролцоо үг нь мэдэхүүний талд тус тус хамаарах мэт болно. Гэвч зарим нь утга ба ухагдахууны ойролцоо үг гэж байхад зарим нь эхийн ба сэдэвчилсэн, жинхэнэ ойролцоо үг гэж гурав ангилсан нь бий. Үүнд: Тухайн эхэд солих боломжтой ойролцоо үгс, эсвэл “*двигаться-ходить-летать-прыгать-скакать, ездить; обувь-туфли*” гэх мэт хөдөлгөөний ба зүйлчилсэн утгатай гэж сэдэвчилсэн ойролцоо үгс, туйлын ойролцоо үг гэж ялгадаг. Үүнээс сэдэвчилсэн үгийг ойролцоо үг гэж тооцдоггүй боловч Ю.Д.Апресян “*төрөл-зүйл*”-ийн үгс (*вымыть-умыть, жалость-сострадание, высокий-рослый*), “*зүйл-зүйл*”-ийн (*жадный-скупой; съезд, конгресс-сессия, пленум-конференция-симпозиум*) зэрэг үгсийг хуурмаг ойролцоо үг³⁴ гэж ангилсан байдаг. Энэчлэн В.Л.Силин “*Ерөнхий ба тодорхой утгыг агуулсан төрөл зүйл заасан үгсийг ойролцоо утгын харьцаанд багтааж болно*”³⁵ гээд энэ нь утга найруулгын ялгааг гаргаж чадах учраас логик ижилслээс ялгаатай гэж үзжээ. Тэрээр, англи хэлний *flour* (будааны дээд зэргийн гурил) гэсэн үг нь *meal* (гурил) гэсэн үгтэй ойролцоо үг болно. Учир нь, үүнд бүхэл хэсэг, төрөл зүйлийн харьцаа байгаа юм гэжээ. Үүнчлэн орос хэлний “*мясь*” хэмээх үг нь “*свиника, баранина, говядина, конина, зайчатина, курятина*” хэмээх үгстэй ойролцоо үг болох ажээ.

Монгол хэлнээ “*хувцас*” гэсэн ерөнхий үг нь “*дээл, гутал, өмд, бүс, малгай, цамц*” гэсэн хэсэг буюу тодорхой үгсийг өөртөө багтааж, тухайн эхийн дотор хувцсыг “*малгай, дээл*” нь орлож болох мэт. Жишээ нь, *Ах хувцсаа/дээлээ өмсөөд гарав. Ах хувцсаа өмсөөд/бүсээ бүслээд гарав* гэх мэт. Р.А.Будагов ойролцоо үгийг хэлэгдэхүүн ба хэлэхүүний тал буюу хэлний ба найруулгын гэж хоёрхон ангилсан бол В.К.Фаворина тодруулах ба төрөл жанрын, яруу өгүүлэх ба эерүүлэх, хувь үгсийн ойролцоо үг гэж ангилсан байх жишээтэй.

П.Г.Черемисин ойролцоо үгийг 1.утгын, 2.туйлын, 3.найруулгын, 4.сэтгэл хөдлөлийн гэж ангилаад, сүүлчийнх нь утга ба найруулгын ойролцоо үгийн дундын шинжтэй гэж үзсэн байна. П.Г.Черемисиний ангилал нь бидний дараах ангилалтай төстэй юм.

М.Базаррагчаа монгол хэлний ойролцоо үгийг хэлний гадаад дотоод тал, хөдлөнг зогсонги тал гэсэн дөрвөн талаас диалектик харьцаанд нь ялгаснаа дараах байдлаар загварчилсан байна.³⁶

³⁴Ю.Д.Апресян (1974) *Лексическая семантика. Синонимические средства языка*. стр. 235, Москва.

³⁵В.Л.Силин (1987) *К проблеме синонимии // Вопросы языкознания*, №4, стр. 95, Москва.


³⁶М.Базаррагчаа (2005) *Монгол хэлний өгүүлбэр судлал*. 153 х., Улаанбаатар.

Нэг юмыг янз бүрээр нэрлэдэг.

Янз бүрийн юмыг нэг ухагдахуунаар нэрлэдэг.

юм-тодорхой


1. аяар нь-, дураар нь-, аяы нь дагуулах-, үгий нь дагуулах-, сэтгэлийн аяар-, салхиар самна-
2. андгайлах-тангараглах, ам өгөх;
хөлөг онгоц-усан онгоц
малгай-овоодой-тоорцог
мануухай-өлзий
мөнгө-зоос-төгрөг-цаас-янчаан
сурагч-шавь-оюутан
дайлах-цайлах-будаалах
бороохой-шийдэм (шаадам)



юмс нь адил

юмын тухай-ерөнхий

1. нүдэнд хүйтэн, нүдний өргөс, харахаас нүд хорсох;
2. сагсуу-бардам-дээрэнгүй
дайрах-довтлох-халдах
шилэх-сонгох
зах-хөвөө-ирмэг-хязгаар
бүрэлгэх-сүйтгэх-үрэх-зарах-егүүтгэх-гарздах
харуул-манаа-цагдуул-сахиул
бэрх-хэцүү-айхавтар-хүнд
бэлдэхсээх-базаах-төхөөрөх
сонсох-дуулах-чагнах
амсах-эдлэх-хүртэх



ухагдахуун адил

үнэлэмж утга

найруулбар

дээд дунд
доод хар яриа

инээх-мишээх-хөхрөх
ярих-өгүүлэх-хүүрнэх-хөөрөх-чалчих
хийх-үйлдэх-бүтээх
уур-унтуу-хилэн
уурлах-унтуулах-хилэгнэх
тэргүүн-толгой-тархи-бөндгөр

утга тодруулах

солих

ижилсэх ондооших
(саармагших) (ялгарах)

эмхлэх-цэгцлэх-багцлах-базах-янзлах-засах-залах
хичээх-мэрийх-чармайх-улайх
хаях-шидэх-орхих-чулуудах-таягдах
төрөх-нярайлах-амаржих-хөнгөрөх
шургуулга-татуурга-ширээний нүд
дайрах-довтлох-халдах-ойртох

М.А.Кронгуаз ойролцоо үгс хэлэхийн цуваанд хэрхэн зохицох буюу тэдгээрийг солих боломжийг дараах байдлаар ангилжээ.³⁷ Үүнд:

а) хос ойролцоо үгийн аль нэгий нь сонгох боломжтой, нөгөөг солих боломжгүй, эх: *“Алба үзүүр дээрээ хүнд*

Ачаа сүүл дээрээ хүнд” гэхэд сүүлчийн “хүнд” гэсэн үгийг *“хэцүү, бэрх, айхавтар”* гэсэн үгсээр сольж болохгүй. Учир нь, энэ үг нь *“жин их”* гэсэн утгатай юм. Харин эхнийхийг дээр үгсээр сольж болно.

б) хос ойролцоо үгийн хоёр дахь гишүүний нь сольж болох ба эхнийхийг сольж болохгүй эх: Монгол хэлнээ *“цоож цуурга”* гэж хорших боловч *“цүүнд дарж торгох нүхтэй төмрийг цүү”* гэх учраас *“...шоронгийн цоож дахин харжигнаж, буутай хоёр гамин орж ирээд, бас л аваад явав”* (С.Дашдэндэв) гэхэд орсон *“цоож”*-ийг *“цуурга”*-аар сольж болохгүй.

в) хос ойролцоо үгс нь утгаараа өөр хоорондоо эсрэгцвэл хоёр гишүүний аль алины нь сольж болох эх: *Алба үзүүр дээрээ хүнд*

Ачаа сүүл дээрээ хүнд гэхэд *“сүүл”* нь утгаа *“амьтны нурууны журмын үзүүрийн яс”* гэсэн утгатай боловч энэ тухайд цагийн төгсгөл гэсэн утгатай *“эцэс”* хэмээх үгтэй утгаараа ойр тул *“эцэс дээрээ”* гэж болно. Жич, *“сүүл”*-тэй ойролцоо *“адаг, бөгс, хууч, шувтарга, дараа, хожим, төгсгөл”* зэрэг үг бий.

г) хос ойролцоо үгс нь утгаараа эсрэгцэхгүй бол хоёр гишүүний аль алины нь сольж болох эх: *“Энэ муу гуанзанд орсон маань юутай сайн болов. Баахан даараад, үхрийн нүдний жүнзээр, халаасан архи ганц нэг оочиж, дулаацъя гэж орсон чинь харин нөхөртэй ингэж уулздаг юм байжээ”* (Б.Ринчен) гэхэд *“уулз-”* (нүүр тулан учрах) гэсэн үг нь өмнөө хамтрахын тийн ялгалт жинхэнэ нэрийг захирах ба *“учир-”* (ерөөлөөр уулзах, тохиолдох, дайралдах) гэсэн үг нь мөн тийн ялгалт үгийг захирах учраас, бас, *“санамсартай санамсаргүй тохиолдох”* гэсэн адил утгыг заах учир дээрх эх доторх *“уулздаг юм байжээ”* гэснийг *“учирдаг юм байжээ”* гэж болно. Уг нь *“уулз-”* гэдэг нь *“тодорхой зорилго агуулсан”* байж болох ба *“учир-”* гэдэг нь *“тодорхой зорилгогүй”* санааг агуулдаг ажээ.

Үүний эхний хоёр нь Ю.Д.Апресяны харилцан нөхөх зохицол (пересечение сочетаемости) болох ба дөрөв дэх нь утгын эсрэгцэл нь хэлэхийн цуваа буюу хэлэхүүний талаас саармагших ёсоор зохицох тул солих боломжтой болжээ. А.А.Брагина ойролцоо нэгжийн үндсэн онцлогийн тухай өгүүлэхдээ *“Хэлэн дэх ойролцоо нэгжийн учир утга нь утга тохирох, харилцан солилцох хоёрхноор дуусахгүй юм. Ойролцоо утга адил байх нь тэдгээрийн хоорондох ялгааг бий болгодог гэж сөргөж болно. Чухамхүү ойролцоо нэгжийн энэ онцлог нь ялгах ба адилсах энэ үүргийг бий болгодог. Үүний ялгах үүрэг нь уул ухагдахуунд хүний хүсэл эрмэлзлээс үүдэлтэй утгын үй олон ялгараа тухайлбал, утгыг нарийвчлах, өргөтгөх эсвэл үүний эсрэг хязгаарлах сөргөцүүлэх зэрэг зүйл илэрч байдаг. Хоёрдогч болох адилсах үүрэг нь хэл ярианы найруулгын элдэв төрөл жанрын шаардлага, саармагших ёс, хар ярианы чөлөөт байдал, толь бичиг болон ярианы явцад хэрэглэдэг “үгийг үгээр тайлбарлах явдлаас шалтгаалдаг”*³⁸ хэмээн өгүүлжээ.

³⁷ М.А.Кронгауз (2005) *Семантика*. стр.143, Москва.

³⁸ А.А.Брагина (1986) *Синонимы в литературном языке*. стр. 23, Москва.